

**ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮРЭЛЦЭЭ БА ОРОН НУТГИЙН
БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦООНЫ УРВУУ ХАМААРАЛ**

**GARDEN ACCESS AND LOCAL ORGANIZATION
INVERSE RELATION OF PARTICIPATION**



М.Маралмаа

*Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
521 дүгээр дамжааны дэд түрүүч*

Товч утга: Монгол улсын цэцэрлэгийн насны буюу 2-5 насны бүх хүүхэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах эрхтэй. Гэтэл улсын хэмжээнд хот, орон нутаг гэлтгүй цэцэрлэгийн барилга байгууламж хомс, багшлах хүчин дутагдалтай зэрэг шалтгаануудын улмаас хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байна. Тиймээс цэцэрлэгийн хүрэлцээг нэмэгдүүлэхэд орон нутгийн байгууллагын оролцоо хэр чухал үүрэг гүйцэтгэдгийг энэхүү илтгэлээрээ харуулахыг зорьсон.

Түлхүүр үгс: Сурч боловсрох эрх, суурь боловсрол, эцэг эх, асран хамгаалагч, багш боловсон хүчин, барилга байгууламж, улсын төсөв, орон нутгийн төсөв, цэцэрлэгийн насны хүүхдийн тоо, цэцэрлэгийн тоо.

Abstract: All children of kindergarten age or 2-5 years of age in Mongolia have the right to participate in pre-school education services. However, not every child can attend kindergarten due to reasons such as lack of kindergarten facilities and lack of teaching staff, both in cities and rural areas. Therefore, this report aims to show how important the participation of local organizations is in increasing the availability of kindergartens.

Keywords: Right to education, basic education, parents, guardians, teaching staff, buildings, state budget, local budget, number of kindergarten age children, number of kindergartens.

Хүүхэд гэдэг улс орны ирээдүй бөгөөд бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих, сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх тухай асуудал нь нэлээдгүй чухал сэдэв юм. Тэгвэл бага насны хүүхэд бүр буюу Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 2 дугаар бүлгийн 7 дугаар зүйлийн 7.1 -т зааснаар хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны бүх хүүхдүүд нь Монгол улсын

үндсэн хуулийн 1 дүгээр бүлгийн 6 дугаар зүйлийн 6.1-т зааснаар бүх шатны боловсролыг хуульд заасан нөхцөл, журмын дагуу төлбөргүй буюу төлбөртэйгээр сурч эзэмших эрхтэй төдийгүй уг хуулийн 6.3-т зааснаар суурь боловсрол заавал эзэмших үүрэгтэй гэж заасан байдаг.

Гэтэл Монгол улсын хэмжээнд цэцэрлэгийн насны буюу 2-5 насны хүүхдүүд бүгд 100 хувь цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа нь сургуулийн өмнөх боловсролын байгууллага буюу цэцэрлэгийн хүрэлцээ дутмаг байгаатай холбоотой юм. Үүнд цэцэрлэгийн барилга байгууламж хомс, төсөв, санхүү дутагдалтай, багшлах боловсон хүчин хангалттай биш зэрэг олон олон асуудлууд хамаарна. Нийслэлийн хэмжээнд гэхэд хүн амын төвлөрөл ихтэй учраас цэцэрлэгийн насны хүүхдүүд их. Гэтэл тэдгээр хүүхдүүдийг бүгдийг нь хамруулах цэцэрлэг хангалтгүй бөгөөд үйл ажиллагаа явуулж байгаа цэцэрлэгүүд нь дийлэнхдээ багтаамжаасаа хэтэрсэн олон хүүхэдтэй буюу нэг ангид дунджаар 20-25 хүүхэд байх ёстой байтал 40-45 хүүхэд суралцдаг байна. Мэдээж багтаамжаасаа хэтэрсэн хүүхэдтэй байх нь багшийн ачааллыг нэмэгдүүлэхээс гадна орон зайн хувьд давчуу, хоол хүнс, ор дэр, тоглоомын хүрэлцээ дутах, хүүхэд бүрийг нэг бүрчлэн тав тухтай орчинд хөгжүүлэх зэрэгт сөргөөр нөлөөлдөг. Үүнээс авч үзвэл цэцэрлэгт хамрагдаж, сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байгаа хүүхдүүдийн Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан эрх төдийлөн хангагдаж чаддаггүй гэж хэлэхэд дэгсдэхгүй болов уу. Харин үүний нөгөө талд цэцэрлэгт огт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдийн эрхийг хэрхэн хангах, энэ чиг үүргийг хэн хэрэгжүүлэх ёстой вэ? Гэдэг асуулт бидний өмнө тулгарсан.

Тэгэхээр сургуулийн өмнөх боловсролыг эзэмшиж чадахгүй байгаа буюу цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдийн сурч боловсрох эрх төдийгүй хамгаалуулах эрх нь зөрчигдөх тохиолдол цөөнгүй байна. Түүнчлэн хүүхдээ цэцэрлэгт хамруулж чадахгүй байгаа эцэг эхчүүдэд ажлаа хийхэд бэрхшээлтэй зарим тохиолдолд ажлаасаа гарах, эсхүл хүүхдээ гэрт нь цоожилж үлдээх, айлд орхих, ажилдаа дагуулж явах зэрэг түгээмэл хүндрэлүүд учирдаг байна. Ингэхлээр хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох эрхүүд нь зөрчигддөг билээ.

Нийслэлийн хэмжээнд төдийгүй орон нутагт ч мөн ялгаагүй цэцэрлэгийн хүрэлцээ муу байгаа бөгөөд эцэг эхчүүд хүүхдээ цэцэрлэгт хамруулахын тулд намар болгон харьяа дүүргийнхээ цэцэрлэгийн үүдэнд хэдэн өдрөөр оочирлодог. Гэсэн ч оочирлосон болгон хүүхдээ цэцэрлэгт хамруулж чаддаггүй бөгөөд жил бүр л энэ талаарх мэдээ мэдээлэл телевиз бүрийн мэдээллийн хөтөлбөрөөр гарч, мэдээллийн сайт болгоноор цацагддаг билээ. Хүүхдийн цэцэрлэг нь улсын төсөв болон орон нутгийн төсвөөс бүрддэг бөгөөд харьяа нутаг дэвсгэр, засаг захиргаа нэгжийн засаг дарга нар энэ талаар хэрэгжүүлэх чиг үүргийнхээ хүрээнд энэ талаарх асуудлыг шийдвэрлэх, гарц гаргалгааг олох үүрэгтэй билээ.

Тэгвэл орон нутгийн байгууллагууд хүүхдийн дээрх сурч боловсрох эрхийг хэрхэн хангах ёстой гэдэг талаар энэхүү илтгэлээрээ хөндөхийг зорьлоо.

Хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах талаар баталгаажуулсан хууль тогтоомжууд: Хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах, хамгаалах, түүнийг зохион байгуулах чиг үүрийн талаар олон улсын хийгээд үндэсний хууль тогтоомжид хэрхэн тусгасан байдаг талаар авч үзье.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 26 дугаар зүйлд хүн бүр сурч боловсрох эрхтэй. Наад зах нь анхан шатны болон ерөнхий боловсрол үнэ төлбөргүй байвал зохино. Анхан шатны боловсролыг заавал эзэмшүүлэх ёстой. Анхан шатны боловсрол гэдэг нь боловсролын эхний үе шатанд хэрэглэгддэг. Энэ нь сургуулийн өмнөх боловсролын тухай буюу өөрөөр хэлбэл, бага боловсролоос өмнө явагддаг сургалтын мөчлөг буюу цэцэрлэгийн үйл явц юм²⁰⁸.

Монгол Улсын Үндсэн хуулийн²⁰⁹ 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсэгт заасан сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно;

Хүүхдийн эрхийн тухай хуулийн²¹⁰ 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх хэсэгт зааснаар хүүхэд бага, суурь, бүрэн дунд боловсролыг үнэ төлбөргүй эзэмших эрхтэй;

Боловсролын тухай хуулийн хуулийн²¹¹ 6 дугаар зүйлийн 6.3-д зааснаар Монгол Улсын иргэн суурь боловсрол заавал эзэмших үүрэгтэй;

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн²¹² 8 дугаар зүйлийн 8.3-т зааснаар цэцэрлэг нь сургуульд элсэхийн өмнөх насны бүх хүүхдэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүргэж, сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана;

Хүүхэд хамгааллын тухай хуулийн²¹³ 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалтад “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор хүүхэд хамгааллын хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажил, үйлчилгээний зардал, нийгмийн ажилтны урамшууллыг улс болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлнэ”;

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн²¹⁴ 16 дугаар зүйлийн 16.3-т зааснаар аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн

²⁰⁸ “Оюутнуудын тухай бүх зүйл” Сурталчилгааны нийтлэлүүд 2023 он.

²⁰⁹ Монгол Улсын Үндсэн хууль. Уб., 1992. Төрийн мэдээлэл эмхэтгэл №1.

²¹⁰ Хүүхдийн эрхийн тухай хууль. Уб., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл №9.

²¹¹ Боловсролын тухай хууль. Уб., 2002. Төрийн мэдээлэл эмхэтгэл №19.

²¹² Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль. Уб., 2008. Төрийн мэдээлэл эмхэтгэл №21.

²¹³ Хүүхэд хамгааллын тухай хууль. Уб., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл №9.

²¹⁴ Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль. Уб., 2021. Төрийн мэдээлэл эмхэтгэл №7.

хөрөнгийг энэ хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулна гэж заасан байдаг буюу уг чиг үүрэгт нь сургуулийн өмнөх боловсролын талаарх үйл ажиллагааг хангах чиглэл тусгагдсан байдаг юм²¹⁵.

Хүүхдийн сурч боловсрох эрхийн талаар дээр дурдсанчлан олон улсын гэрээ, конвенц, хууль, дүрэм журмуудад тусгагдаж эрх зүйн орчин нь баталгаажуулсан байгаа хэдий ч хэрэгжилт нь төдийлөн хангалттай байхгүй байна гэж судлаач оюутны зүгээс харж байна.

Хүүхдийн эрхийг хангахад орон нутгийн байгууллагуудын оролцоо: Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиг үүргийг эцэг, эх, асран хамгаалагч, боловсролын байгууллагын ажилтан, албан хаагчаас гадна засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, эрх бүхий албан тушаалтан ч тодорхой чиг үүрэгтэй оролцдог. Энэхүү чиг үүргийг холбогдох хууль, тогтоомжид хэрхэн тусгасан байдаг талаар авч үзье.

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хуулийн 20 дугаар зүйлд орон нутгийн чиг үүрэгт хамаарах асуудлуудыг заасан байдаг бөгөөд 20.1.18 дахь хэсэгт “Төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар” үйлчилгээг хангах, мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.5-д зааснаар “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар дараах төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлнэ” гэсэн байдаг ба үүнд нь буюу 27.5.2-т сургуулийн өмнөх боловсрол тусгагдсан байдаг.


Хүүхдийн эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд Улсын их хурал, нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхийг тусгасан бөгөөд 11.1.1 дэх хэсэгт хүүхдийн эрхийг хангах талаарх төрийн болон орон нутгийн бодлогыг тодорхойлох, 11.1.2 дахь хэсэгт хүүхдийн эрхийг хангах, хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр, үйл ажиллагааг санхүүжүүлэх, төсөв батлах, 11.1.3 дахь хэсэгт хүүхдийн эрхийн талаарх хууль тогтоомжид хяналт тавих хэмээн тус тус заасан байдаг байна.

Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлд аймаг нийслэлийн боловсролын газрын бүрэн эрхийг тусгасан бөгөөд 28.1.1 дэх хэсэгт боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах, 28.1.2 дахь хэсэгт ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах зөвшөөрөл олгох эсэх талаар дүгнэлт гаргаж аймаг, нийслэлийн Засаг даргад санал болгох, 28.1.6 дахь хэсэгт орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойрог тогтоох хэмээн тусгасан байна.

²¹⁵ Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 27 дугаар зүйлийн 27.5.2

Мөн хуулийн 30 дугаар зүйлд аймаг нийслэлийн засаг даргын бүрэн эрхийг хуульчилсан бөгөөд 30.1.2 дахь хэсэгт иргэнд суурь боловсрол эзэмшүүлэх, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, мэргэжил эзэмшүүлэх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх, 30.1.3.орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг аймаг, нийслэлийн боловсролын газрын дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэх, 30.1.4.өөрийн орлогоо нэмэгдүүлэхэд нь боловсролын байгууллагад дэмжлэг үзүүлэх, тэдгээрийг хичээлийн болон дотуур байр, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ном, сурах бичгээр хангах ажлыг зохион байгуулах зэрэг чиг үүргүүдийг тусгасан байна.

Түүнчлэн уг хуулийн 31 дүгээр зүйлд сум, дүүргийн засаг даргын бүрэн эрхийг хуульчилсан бөгөөд 31.1.1 дэх хэсэгт боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, 31.1.2 дахь хэсэгт хүүхдэд сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, иргэнд суурь боловсрол нөхөн эзэмшүүлэх ажлыг захиргааны удирдлагаар хангах зэрэг бүрэн эрхүүдийг тус тус хэрэгжүүлэхээр хуульчлагдсан. Хүүхдийн эрхийг хангах, тэдний сурч боловсрох, гэмт хэрэг, халдлагаас хамгаалуулах, эрүүл, аюулгүй орчинд өсч бойжих эрхийн хууль зүйн хамгаалалтыг бид сайн хийсэн байна. Гэвч эдгээр хууль зүйн хамгаалалтын хэрэгжилт хууль тогтоогчийн зорилгод хүрч үйлчлэхгүй байгаатай хэн бүхэн санал нийлэх байх. Үүнийг дараах статистик үзүүлэлтээс илүү тодорхой харж болохоор байна.



Хүүхдийн хүмүүжил 0-6 насанд эрчимтэй явагдаж 10-12 нас гэхэд хүмүүжлийн суурь тавигдаж дуусдаг²¹⁶. Тэгэхээр тэрхүү эрчимтэй явагдах насанд хүүхдэд

сургуулийн өмнөх боловсрол зайлшгүй чухал шаардлагатай бөгөөд цэцэрлэгийн насны 2-5 насны хүүхдүүдийг бүрэн цэцэрлэгт хамруулах нь хүүхдийн хүмүүжил төлөвшилд чухал нөлөө үзүүлэх юм.

²¹⁶ "Тогтвортой хөгжил - Ерөнхий боловсрол" улсын II зөвлөгөөн, "Монгол хүүхдийн хөгжлийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал" илтгэл

Монгол улсын хэмжээнд 2022 оны байдлаар төрийн өмчит цэцэрлэг 985, хувийн өмчит цэцэрлэг 428 бүртгэгдсэн байна²¹⁷.



Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлдэг байгууллагын тоон үзүүлэлт нь сүүлийн 10 жилийн байдлаар 400 гаруй байгууллагаар нэмэгдсэн хэдий ч сүүлийн 5 жилийн хугацаанд 2-3 байгууллагаар л өссөн үзүүлэлттэй харагдаж байна²¹⁸.

Энэ нь хүн амын өсөлт, нийт тухайн үйлчилгээнд хамрагдвал зохих хүүхдийн тоотой харьцуулахад маш бага байгааг дараах судалгаануудаас харах боломжтой.

Монгол улсын хэмжээнд 2021 оны байдлаар цэцэрлэгийн насны буюу 2-5 насны 303766 хүүхэд бүртгэгдсэн бөгөөд үүнээс 190991 хүүхэд нь цэцэрлэгт



хамрагдсан буюу цаана нь 112775 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж чадаагүй байна.

Харин энэ оны байдлаар 0-5 хүртэлх насны буюу цэцэрлэгт хамрагдвал зохих хүүхдийн тоон үзүүлэлт тодорхойгүй

ч 2022-2023 оны хичээлийн жилд 266024 хүүхэд сургуулийн өмнөх боловсролын байгууллын үйл ажиллагаанд хамрагдаж байгаа статистик үзүүлэлт гарсан байна²¹⁹.

²¹⁷ [СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН 2022-2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭ](#) | Боловсрол, шинжлэх ухааны яам. ([meds.gov.mn](#))

²¹⁸ Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлдэг төрийн болон хувийн өмчийн байгууллагын судалгаа. Уб., 2023. [Боловсрол, шинжлэх ухааны яам \(meds.gov.mn\)](#)

²¹⁹ [СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН 2022-2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭ](#) | Боловсрол, шинжлэх ухааны яам. ([meds.gov.mn](#))

Дараах хүснэгтээс 2021 оны байдлаар 2-5 насны хүүхдүүдийг насны бүлгээр нь ангилсан үзүүлэлтийг харуулъя.²²⁰



Дээрх судалгаанаас харахад 5 настай хүүхдүүд хамгийн их байгаа нь харагдаж байна. Цэцэрлэгийн бэлтгэл бүлэг буюу 5 настангууд нь сургуульд орохоос өмнөх бэлтгэлээ

хангадаг хамгийн чухал үе билээ. Тэгэхээр энэ насны хүүхдүүд бүгд цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа нь учир дутагдалтай.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын салбарын 2022-2023 оны хичээлийн жилийн зорилго зорилтод “Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, 5 настай хүүхэд бүрийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулан сургуульд сурах бэлтгэлийг хангах” гэсэн зорилго тусгагдсан байдаг байна²²¹.

Мөн Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн насыг 3-5 болгож, 5 настай хүүхэд бүрийг сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана” гэсэн зорилтыг дэвшүүлсэн байна²²².

Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд 2021-2022 оны хичээлийн жилд 69749 хүүхэд хамрагдаагүй бөгөөд тэдгээр хамрагдаагүй хүүхдүүдийг нас, хувь, байршилаар нь харцгаая.²²³

Нас	Тоо	Эзлэх хувь
2 нас	40254	57.5%
3 нас	20665	29.6%
4 нас	5173	7.4%
5 нас	3657	5.2%

Дээрх нийт цэцэрлэгт хамрагдаагүй 69749 хүүхдийн 32553 нь хөдөө орон нутагт, 37196 нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.²²⁴


²²⁰ Үндэсний статистикийн хороо, Уб., 2023 он.

²²¹ Боловсрол соёл шинжлэх ухааны яам

²²² Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем

²²³ Монголын үндэсний мэдээллийн агентлаг МОНЦЕМА, 2022 он.

²²⁴ Боловсрол соёл шинжлэх ухааны яам



Мөн нийслэлийн 57 байршилд цэцэрлэгийн хэт өндөр ачаалал үүссэн бөгөөд цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа юм.

Дүүрэг	Төрийн өмчит цэцэрлэгийн тоо	Хэт өндөр ачаалалтай цэцэрлэгийн тоо	Эзлэх хувь
Баянгол	35	4	11.7%
Баянзүрх	52	19	36.5%
Налайх	10	2	20.0%
Сүхбаатар	35	7	20.0%
Сонгинохайрхан	60	9	15.0%
Хан-Уул	30	10	33.3%
Чингэлтэй	36	6	16.6%
Нийт	258	57	22.1%

Зөвхөн Улаанбаатар хотын хэмжээнд гэхэд л нийт 258 цэцэрлэгийн 57 нь хэт өндөр ачаалалтай үйл ажиллагаа явуулж байгаа нь тулгамдаж буй асуудал бөгөөд тэдгээр цэцэрлэгийг өргөтгөх, нэмж цэцэрлэг барих зэрэг асуудал тулгамдаж байгаа юм.

Дүгнэлт

Сургуулийн өмнөх боловсрол нь хүүхэд сургуульд орохоос өмнөх урьтал бэлтгэл үе бөгөөд хүүхдийн хүмүүжил төлөвшилд чухал нөлөө үзүүлэх боловсролын байгууллага билээ. Дээр дурдсан цэцэрлэгийн хүрэлцээгүй байдал, хэт ачаалал зэргээс шалтгаалж цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдийн хувьд тэдний үндсэн хуулиар олгогдсон болон бусад холбогдох хууль

тогтоомжуудаар баталгаажсан сурч боловсрох эрх нь зөрчигдөж байгааг харуулж байгаа юм.

Цэцэрлэгийн хүрэлцээ хангалтгүй байгаагаас болж цэцэрлэгийн насны хүүхдүүд бүгд 100 хувь цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа бөгөөд ингэснээр дан ганц сурч боловсрох эрхээс гадна эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх нь ч мөн давхар зөрчигдөх нөхцөл байдал бий болж байгаа юм. Тиймээс хүүхдийн цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх, ачаалал ихтэй цэцэрлэгт өргөтгөл хийх зэрэг арга хэмжээнүүдийг авах шаардлагатай байгаа юм. мөн төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэхэд тухайн орон нутаг, засаг захиргааны дарга нар анхаарч ач холбогдол өгөн ажиллах шаардлагатай байна. Түүнчлэн дан ганц төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх гэж туйлширахаасаа гадна хувийн өмчийн цэцэрлэгийг нэмэгдүүлэхэд шаардлагатай нөхцөл боломжоор хангах хэрэгтэй.

Мөн боловсролын салбарт зориулах улсын болон орон нутгийн төсвийг нэмэгдүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг шат шатны засаг дарга, орон нутгийн байгууллагууд авч ажиллах хэрэгтэй.

Цэцэрлэгийн тоо өссөнөөр хүүхдийн сурч боловсрох эрх хангагдаж, ажлын байр ч нэмэгдэх боломжтой. Мөн хүүхэд нь цэцэрлэгт явж аюулгүй байдлаа хангуулж байгаа нөхцөлд эцэг, эхчүүд нь ажил хийх нь тухайн өрхийн амьжиргаа, орлогыг нэмэгдүүлэхээс гадна улс орны эдийн засагт ч сайнаар нөлөө үзүүлэх боломжтой гэж харж байна. Өнгөц харахад дан ганц цэцэрлэгийн хүрэлцээний асуудал мэт харагдаж болох ч нарийн харвал цаанаа олон олон асуудлыг давхар хамруулж байгаа юм. Тиймээс тэрхүү цэцэрлэгийн асуудал хангагдаж чадахгүй байгаагаас улс орны ирээдүй болсон хүүхдүүдийн суурь хүмүүжил, төлөвшил зөв тавигдахгүй, ажилтай, орлоготой иргэдийн тоо ч бага байгаа нь иргэдийн анхдагч хэрэгцээ болсон суурь боловсролыг чанартай эзэмших, эзэмших боломж хомс байгаатай холбоотой гэж харж байгаа юм.

Мөн цэцэрлэгийн үйл ажиллагаанд төдийлөн анхаарахгүй байгаа нь боловсролын чанарын үзүүлэлттэй шууд хамааралтай юм.

Тиймээс боловсролын асуудлын талаар, тэр дундаа сургуулийн өмнөх боловсролын талаарх үйл ажиллагааг дан ганц боловсролын байгууллагатай холбож, бүх үүрэг хариуцлагыг оноохоос илүүтэйгээр орон нутгийн байгууллагууд тус бүр энэ чиглэлд анхаарлаа хандуулж үйл ажиллагаагаа эрчимжүүлснээр энэ талын асуудлуудад анхаарлаа хандуулах байгууллагууд олширч авах арга хэмжээ нь ч мөн дорвитой болох юм. Өөрөөр хэлбэл орон нутгийн байгууллага, иргэдийн төлөөлөгчдийн хурал энэ тал дээр онцгой анхаарах цаг нь болсон гэж харж байна.

Санал